

**ТАВАНТОЛГОЙ ХК**  
**ӨМНӨГОВЬ АЙМАГ**  
**“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН**  
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН**  
**ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 40

Цогтцэций сум

Гүйцэтгэх захирлыг үүрэгт ажлаас  
чөлөөлөх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь заалт, 83 дугаар зүйлийн 83.15, 84 дүгээр зүйлийн 84.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.1, 78 дугаар зүйлийн 78.1.9, 79 дүгээр зүйлийн 79.3 дахь хэсэг, “Тавантолгой” Хувьцаат компанийн дүрмийн хоёрын 2.3, долоогийн 7.4.7, арвын 10.1 дэх хэсгийг тус тус үндэслэн, Гүйцэтгэх захирал Ч.Гүнждагвын өргөдлийг хэлэлцээд “Тавантолгой” Хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” Хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал Ч.Гүнждагвын эрүүл мэндийн шалтгааны улмаас Төлөөлөн Удирдах зөвлөлд гаргасан өргөдлийг харгалзан 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрөөр хөдөлмөрийн харилцааг дуусгавар болгож Компанийн Гүйцэтгэх захирлын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.
2. Ч.Гүнждагва ажлаас чөлөөлөгдсөнтэй холбоотойгоор холбогдох санхүүгийн тооцоог бүрэн хийж дуусгахыг компанийн Санхүү, эдийн засаг, төлөвлөлтийн газрын захирал (Б.Нарантуяа), Нягтан бодох бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтан бодогч (Д.Энхсаруул) нарт даалгасугай.





ӨМНӨГОВЬ АЙМАГ  
“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 06 сарын 22 өдөр

Дугаар 41

Цогтцэций сум

Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон  
гүйцэтгэгч томилох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, 56.2 дахь хэсэг, “Тавантолгой” Хувьцаат компанийн дүрмийн хоёрын 2.3, долоогийн 7.4.17 дахь заалт, Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2025 оны 05 дугаар тогтоол, 40 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн “Тавантолгой” Хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Компанийн гүйцэтгэх захирал Ч.Гүнждагва ажлаас чөлөөлөгдсөнтэй холбоотойгоор Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр компанийн Захиргаа, удирдлагын газрын захирал (С.Идэрсүрэн)-г томилсугай.
2. Компанийг хууль, дүрмийн дагуу нэгдсэн удирдлагаар хангаж, аливаа гаргах шийдвэрийг хууль тогтоомжийн хүрээнд шуурхай арга хэмжээ авч, Төлөөлөн Удирдах зөвлөлд танилцуулж, идэвх санаачилгатай ажиллахыг компанийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Захиргаа, удирдлагын газрын захирал (С.Идэрсүрэн)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ОТГОНБАЯР



ӨМНӨГОВЬ АЙМАГ  
“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 902

Цогтцэций сум

Комисс байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь заалт, “Тавантолгой” Хувьцаат компанийн дүрмийн хоёрын 2.3, долоогийн 7.4.17 дахь заалт, Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2025 оны өдрийн 40 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн “Тавантолгой” Хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал Ч.Гүнждагвуун ажлыг хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Б.Мэндбаяр /Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн/  
Гишүүд: С.Мятивдорж /Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн/  
Б.Батсүрэн /Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн/

Нарийн бичиг: Ч.Отгонбаяр /Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн/

2. Ч.Гүнждагватай ажил хүлээлцэх үйл ажиллагааг хууль тогтоомж, дүрэм журмын дагуу зохион байгуулж, холбогдох баримт бичиг, бүх төрлийн мэдээллийн системийн нэвтрэх эрх, эд хөрөнгийг бүрэн тоолон хүлээж авч ажиллахыг Комиссын дарга (Б.Мэндбаяр)-д даалгасугай.

ДАРГА

Ш.ОТГОНБАЯР



**ТАВАНТОЛГОЙ ХК**  
**ӨМНӨГОВЬ АЙМАГ**  
**“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН**  
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН**  
**ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 43

Цогтцэций сум

Төлөөлөн Удирдах зөвлөлийн нарийн бичгийн  
даргыг үүрэгт ажлаас чөлөөлөх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.1, 78 дугаар зүйлийн 78.1.9 дэх заалт, 79 дүгээр зүйлийн 79.3 дахь хэсэг, “Тавантолгой” Хувьцаат компанийн дурмийн хоёрын 2.3, долоогийн 7.4.17 дахь заалтыг тус тус үндэслэн, Төлөөлөн Удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Н.Адъяацэрэнгийн ажлаас чөлөөлөгдөх өргөдлийг хэлэлцээд “Тавантолгой” Хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” Хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Н.Адъяацэрэнгийн хөдөлмөрийн харилцааг 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрөөр дуусгавар болгож Төлөөлөн Удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.
2. Н.Адъяацэрэн ажлаас чөлөөлөгдсөнтэй холбогдуулан холбогдох санхүүгийн тооцоог бүрэн хийж дуусгахыг компанийн Санхүү, эдийн засаг, төлөвлөлтийн газрын захирал (Б.Нарантуяа), Нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч (Д.Энхсаруул) нарт даалгасугай.



**ТАВАНТОЛГОЙ ХК**  
**ӨМНӨГОВЬ АЙМАГ**  
**“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН**  
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН**  
**ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 44

Цогтцэций сум

Г Ажил түр хавсран гүйцэтгүүлэх тухай Г

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэг, “Тавантолгой” Хувьцаат компанийн дүрмийн хоёрын 2.3, долоогийн 7.4.17 дахь заалт, Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2025 оны 43 дугаар тогтоолыг тус тус үндэслэн “Тавантолгой” Хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” Хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Н.Адъяацэрэн ажлаас чөлөөлөгдсөнтэй холбоотойгоор нарийн бичгийн даргын ажлыг түр хавсран гүйцэтгэгчээр компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Э.Бөхбатыг томилсугай.
2. Н.Адъяацэрэнтэй ажил хүлээлцэх үйл ажиллагааг хууль тогтоомж, дүрэм журмын дагуу зохион байгуулж, холбогдох баримт бичиг, эд хөрөнгийг бүрэн тоолон хүлээж авч ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн (Э.Бөхбат)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ОТГОНБАЯР